



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2013 оны 10 сарын 23 өдөр

Дугаар 371

Улаанбаатар хот

“Архуст шунхлай” ХК-ийн үнэт цаасны
бүртгэлд өөрчлөлт оруулах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 6.1.2, 34.1.1, “Ар хуст шунхлай” ХК-ийн 2012 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн хурлын 03, 05 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Архуст шунхлай” ХК-ийн оноосон нэрийг “Евроазиа капитал холдинг” ХК болгон өөрчилж үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулахыг Үнэт цаасны газар /Б.Саруул/, хөрөнгийн биржийн жагсаалтад өөрчлөлт оруулахыг “Монголын хөрөнгийн бирж” ХК /Х.Алтай/, үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн бүртгэлд өөрчлөлт оруулахыг “ҮЦТТХТ” ХХК /Т.Гандулам/-д тус тус үүрэг болгосугай.

2. Үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт орсонтой холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг “Евроазиа капитал холдинг” ХК /Г.Оюунболд/-д үүрэг болгосугай:

1/ Энэхүү тогтоолын 1-т заасан оноосон нэрийн өөрчлөлтийг хуульд заасан журмын дагуу улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлж, энэ тухай Хороонд мэдэгдэх;

2/ Санхүүгийн зохицуулах хорооны 2007 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Үнэт цаасны зах зээлийн мэдээллийн нэгдсэн сангийн тухай журам”-д заасан мэдээллийг цаг тухайд нь тогтмол ирүүлж, хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ чанд биелүүлж ажиллах;

3/ Санхүүгийн зохицуулах хорооны 2007 оны 210 дугаар тогтоолоор батлагдсан “Монголын компанийн засаглалын кодекс”-ийг үйл ажиллагаандаа чанд баримталж, хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалж ажиллах.

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээллэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА



ДБАЯРСАЙХАН

330822